



СЭЛЭНГЭ АЙМАГ
УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/25

Сүхбаатар сум

Албан хаагчид ур чадварын нэмэгдэл
олгох шалгуур үзүүлэлт, үнэлгээний
журам батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, "Төрийн албаны тухай" хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам"-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, үнэлгээний журам"-ыг 1 хавсралтаар баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлсүгэй.

2.Батлагдсан журмын дагуу ур чадварын нэмэгдэл олгохыг Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.

3.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цаг уур, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, Ус, орчны шинжилгээний хэлтсийн дарга, Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Ур чадварын нэмэгдэл олгох тухай төвийн даргын 2022 оны А/18 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.


О.ГАНБАТ

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/25 тоот тушаалын хавсралт

ТӨВИЙН АЛБАН ХААГЧИД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгохдоо "Төвийн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, үнэлгээний журам"-ыг (цаашид журам гэнэ) баримтална.

1.2. Албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, үр бүтээлтэй ажиллуулах, идэвх санаачилгыг нь дэмжих зорилгоор энэхүү журмыг хэрэглэх бөгөөд Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А/170 тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам"-д заасан үнэлгээ, нэмэгдлийн хувийг үндэслэн сар бүр олгоно.

1.3. Уг журмыг албан хаагчийн гүйцэтгэж байгаа ажил, мэргэжилтэй холбоотой үнэлэх, дүгнэх журам, шинжилгээний ажлын хөтөлбөр, тогтоол шийдвэрт өөрчлөлт орсон тохиолдолд дахин боловсруулж болно.

1.4. Албан хаагч ур чадварын шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан тайлангаа дараа улирлын эхний сарын (1, 4, 7, 10 дугаар сарын) 8-ны дотор харьяалах хэлтэстээ, 10-ны дотор тухайн хэлтсийн дарга баталгаажуулж захиргаанд ирүүлсэн байна.

Хоёр. Нийтлэг шалгуур үзүүлэлт

Ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

- 2.1. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг "Хангалттай" түвшинд биелүүлсэн байх;
- 2.2. Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх;
- 2.3. Авлига, албан тушаалын болон санхүүгийн зөрчилгүй байх;
- 2.4. Хөдөлмөрийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт "Хангалттай" түвшинд үнэлэгдсэн байх;

Гурав. Тусгай шалгуур үзүүлэлт

Нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтны ур чадварыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Захиргааны болон Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын хэлтсийн даргын тусгай шалгуур үзүүлэлт:

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлал, менежментийн	Ажилтнуудын үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, үр дүнд хүрсэн	15

ур чадвар	Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	25
	Мэргэшил мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдал, үр дүн /мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал/	20
Ажлын үр дүн	Улирлын ажлын үр дүнгийн үнэлгээ, ажлын ахиц, амжилт	20
	Шинэлэг санаа, санал санаачилга гаргаж хэрэгжүүлсэн	10
	Ажлын цаг ашиглалт	10

3.2. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын **ерөнхий технологич, технологич инженер, инженерийн тусгай шалгуур үзүүлэлт:**

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн ур чадвар	Мэргэшлийн онол, арга зүйн мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлсэн байдал, үр дүн /мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал/	20
	Арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал	20
Ажлын үр дүн	Улирлын шинжилгээний ажлын ахиц, амжилт	20
	Шинэлэг санаа, санал санаачилга	20
	Салбарын ажлын онцлогтой уялдуулан ажлын үр дүнг 3.3-аар үнэлнэ.	10
	Ажлын цаг ашиглалт	10

3.3. Салбарын ерөнхий технологич, ерөнхий инженер, инженерийн тусгай шалгуурын ажлын үр дүнгийн 3 дахь үзүүлэлтийг салбарын шинжилгээний ажлын хөтөлбөрийн онцлогтой уялдуулан дараах үзүүлэлтээр үнэлнэ.

Урьдчилан мэдээлэх: Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлсэн мэдээний таарц, чанар

Хөдөө аж ахуй: Цаг агаарын аюултай үзэгдлийн ургамалд үзүүлэх нөлөөллийг урьдчилж тооцох, мэдээлэх, сэрэмжлүүлэх, зөвлөмж мэдээлэл хүргэсэн байдал, судалгааны ажил хийх

Уур амьсгал: Ус, цаг уур, орчны хөтөлбөрт шинжилгээний ажилд ашиглаж байгаа багаж, тоног төхөөрөмжийн гэмтлийг урьдчилсан үзлэгээр илрүүлэх, судалгаа хийх, шинэ багаж судлах, эрэл хайлт хийх, уур амьсгалын судалгааны ажил хийх

Мэдээлэл холбоо, сүлжээ: Сүлжээний төхөөрөмж, автомат хэмжлийн багаж, компьютер техник хэрэгсэл гэмтэж эвдрэхээс урьдчилан хамгаалж урьдчилан илрүүлэх, засвар үйлчилгээг хийж сурсан байдал

Мэдээллийн дэд сан: Шинжилгээний архивын мэдээллээр төлбөртэй үйлчилсэн байдал, судалгааны ажил хийх

Ус судлалын салбар: Үер, усны гамшигт үзэгдлийг урьдчилан тооцож анхааруулах, мэдээллийг нэгтгэж боловсруулах, судалгаа хийх, тайлагнах, мэдээлэх

БОШЛаборатори: Орчны бохирдлын эх үүсвэрийн нөлөөлөл, орчны чанарын өөрчлөлтийг хянах, мэдээлэх, судалгаа хийх

Цаг уурын өртөө: Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, аюул агаар /ААМО/, 10 хоног тутмын климат, хөдөө аж ахуйн цаг уурын агро дундаж мэдээнүүд болон орчны бохирдлын /цацрагийн/ мэдээллийг боловсруулж алдаагүй мэдээлсэн байдал, судалгааны ажил

Хүний нөөц: Хүний нөөцийн судалгаа хийж дүгнэлт гаргах, сургалт, хөтөлбөр,

болон орчны бохирдлын /цацрагийн/ мэдээллийг боловсруулж алдаагүй мэдээлсэн байдал, судалгааны ажил

Хүний нөөц: Хүний нөөцийн судалгаа хийж дүгнэлт гаргах, сургалт, хөтөлбөр, төлөвлөлтийг зөв хийх, тулгамдаж буй асуудлын шийдвэр, гарцыг тодорхойлж үр дүнд хүрсэн байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй: Ажлын байран дахь урьдчилан мэдэх боломжгүй, болзошгүй эрсдэлийг олж илрүүлсэн, арилгасан, тулгамдаж буй асуудлын шийдлийг зөв тодорхойлж үр дүнд хүрсэн байдал

3.4. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын **техникч, ажиглагчийн** тусгай шалгуур үзүүлэлт:

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн ур чадвар	Мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдал, үр дүн /мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал/	20
	Арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал, шинэлэг санаа, санал санаачилга	15
Ажлын үр дүн	Улирлын шинжилгээний ажилд гарсан ахиц, амжилт	30
	1. Ус, цаг уур, цацраг, агаар чанарын ажиглалтын хугацааны шуурхай мэдээ 2. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, аюул агаар /ААМО/ мэдээг 3. Цаг уурын 10 хоног тутмын болон сарын климат мэдээ 4. Ус судлалын 10 хоног тутмын мэдээ 5. Агаарын чанарын 7 хоног тутмын, сарын тойм мэдээ 6. ХАА-н цаг уурын 10 хоногийн агро дундаж мэдээ 7. Орчны бохирдлын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээг алдаагүй зохиож хяналтын хугацаанд дамжуулсан байдал	20
Мэдээлэл сурталчилгаа	Байгууллага, салбарын үйл ажиллагааг сурталчилах, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл, орчны бохирдлын өөрчлөлтийн урьдчилсан мэдээг цахим технологи ашиглаж, нэвтрүүлж хэрэглэгчдэд хүргэж, үйлчилсэн байдал	5
	Цаг ашиглалт	10

3.5. Захиргааны архив, бичиг хэргийн ажилтан, жолооч, үйлчлэгч, жижүүрийн тусгай шалгуур үзүүлэлт:

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Мэргэжлийн ур чадвар	Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хяналт тавьсан байдал	20
	Ажилтануудын үнэлгээгээр хангалттай үнэлэгдсэн байдал	20
Ажлын үр дүн	Хариуцсан ажлаа батлагдсан хуваарийн дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн байдал, гарсан ахиц, амжилт	30
	Арга туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн байдал, шинэлэг санаа, санал санаачилга	20
	Цаг ашиглалт	10

Дөрөв. Шалгуур үзүүлэлтийг үнэлж, дүгнэх

4.1. Дөрөв. Шалгуур үзүүлэлтийг үнэлж, дүгнэх 4.1. Энэхүү журмын 3.1, 3.3, 3.4, 3.5д заасан шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 80.0 ба түүнээс дээш хувиар үнэлэгдсэн албан хаагчийн ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн, хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 80.0-85.0 хувь 85.1-90.0 хувь 90.1-95.0 хувь 95.1-100 хувь Ур

чадварын нэмэгдлийн хувь 10% 15% 20% 25% 4.2.Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 80.0 болон түүнээс дээш хувийг хангасан албан хаагчид тухайн жилийн төсөвт багтаан ур чадварын нэмэгдлийг олгоно.

Энэхүү журмын 3.1, 3.3, 3.4, 3.5 -д заасан шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 80.0 ба түүнээс дээш хувиар үнэлэгдсэн албан хаагчийн ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн, хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	80.0-85.0 хувь	85.1-90.0 хувь	90.1-95.0 хувь	95.1-100 хувь
Ур чадварын нэмэгдлийн хувь	10%	15%	20%	25%

4.2.Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 80.0 болон түүнээс дээш хувийг хангасан албан хаагчид тухайн жилийн төсөвт багтаан ур чадварын нэмэгдлийг олгоно.

4.3.Албан хаагчийн ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг улирал бүрийн 15-ны дотор зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэн даргын тушаалаар олгоно.

4.4.Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаас гадна эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлыг харгалзан олгохыг хориглоно.

—oO—oOo—